“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 19 өдөр Дугаар А/78 Улаанбаатар хот

“Баганууурын дулааны станц”ТӨХК-ийн
оны шилдэг ажилтан шалгаруулах
журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, “Баганууурын дулааны станц” ТӨХК-ийн захиргаа-Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2023-2024 онд байгуулсан хамтын гэрээний 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг, “Баганууурын дулааны станц”ТӨХК-ийн Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.7, 8.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Баганууурын дулааны станц”ТӨХК-ийн оны шилдэг ажилтан шалгаруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан журмыг нийт ажиллагсдад танилцуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг алба, хэлтэс, хэсэг, нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.АРИУН-ЭРДЭНЭ

"Багануурын дулааны станц"ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 20...оны ...сарын
19...-ны өдрийн ...дүгээр тушаалын хавсралт

"БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК-ИЙН ОНЫ ШИЛДЭГ АЖИЛТАН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр хийгдсэн ажил болон тэдгээрийг амжилттай хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан ажилтны бүтээлч идэвх санаачлагыг өрнүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Тус байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг ажилтнууд.

Гурав. Шагналын төрөл, хэмжээ

3.1. Байгууллагын хүндэт дэвтэрт бичиж алдаршуулах-1, салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэн мөнгөн дүнгээр

3.2 Хөдөлмөрийн аварга-1, салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэн мөнгөн дүнгээр

3.3 Тэргүүний инженер техникийн ажилтан-1, салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2,5 дахин нэмэгдүүлсэн мөнгөн дүнгээр

3.4 Тэргүүний ажилтан-5, салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2,5 дахин нэмэгдүүлсэн мөнгөн дүнгээр

Дөрөв. Нэр дэвшүүлэх

4.1. Дараах шагналуудад нэр дэвшүүлнэ. Үүнд:

4.1.1. Хамт олноо хошуучлан байгууллагынхаа амжилтыг ахиулахад идэвх санаачлага, үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан байдлыг харгалзан "Байгууллагын хүндэт дэвтэрт бичигдэх ажилтан"-1," Хөдөлмөрийн аварга"-1, "Тэргүүний инженер техникийн ажилтан"-1, "Тэргүүний ажилтан"-5-ийг алба, хэлтэс, хэсэг, нэгжүүдээс тодорхойлж нэрийг нь дэвшүүлнэ.

Тав. Шалгуур үзүүлэлт

5.1. "Байгууллагын хүндэт дэвтэрт бичиж алдаршуулах" ажилтан шалгаруулах шалгуур үзүүлэлт

Үндсэн үзүүлэлт:

- Тухайн байгууллагад 20-оос доошгүй жил үндсэн ажилтнаар үр бүтээлтэй ажилласан байх

Тусгай үзүүлэлт /Дараах үзүүлэлтийг хангасан байх/

5.1.1. Сүүлийн 3 жилийн хугацаанд өөрийн буруугаас аваарь, осол, хөрөнгө ашиглан шамшигдуулсан зөрчил гаргаж байгаагүй байх-20 оноо

5.1.2. Шинэ техник, технологи, аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байх, эдийн засгийн үр ашигтай ажилласан байх-20 оноо

5.1.3-Ажилласан хугацаандаа шинэ залуу ажиллагсдыг дагалдуулан сургасан байх-20 оноо

5.1.4-Хамт олондоо нэр хүндтэй, ажил үйлсээрээ бусдыгаа хошуучлан ажилладаг байх-20 оноо

5.1.5-Байгууллагаа төлөөлөн дүүрэг, салбар, улсын хэмжээнд зохиогдсон мэргэжлийн болон урлаг, спортын чиглэлээр уралдаан тэмцээнд оролцож амжилт үзүүлсэн байх, байгууллагын тэргүүний ажилтан, Хөдөлмөрийн аварга, Тэргүүний инженер техникийн ажилтны аль нэгээр 1 удаа шалгарсан байх

5.2 "Хөдөлмөрийн аварга" шалгаруулах шалгуур үзүүлэлт

Үндсэн үзүүлэлт:

- Тухайн байгууллагад 5-аас доошгүй жил үндсэн ажилтнаар үр бүтээлтэй ажилласан байх;

Тусгай үзүүлэлт/Тухайн ондоо дараах үзүүлэлтийг хангасан байх/

5.2.1. Тухайн ондоо хөдөлмөрийн сахилгын шийтгэл хүлээгээгүй байх-20 оноо

5.2.2. Шинэ техник, технологи, аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байх-20 оноо

5.2.3 Олон нийтийн арга хэмжээнд идэвхитэй оролцдог байдал, ажлын цаг ашиглалт, ажлаа цалгардуулдаггүй байдал-20 оноо

5.2.4 Байгууллагын тэргүүний ажилтан, байгууллагын тэргүүний инженер техникийн ажилтны аль нэгээр нэг удаа шалгарсан байх-20 оноо

5.2.5 Тухайн жилдээ 1-ээс доошгүй бүтээлч ажил хийж, шинэ санаачилга гаргасан байх, эдийн засгийн үр ашигтай, хэмнэлт гаргасан байх-20 оноо

5.3 Тэргүүний инженер техникийн ажилтан шалгаруулах шалгуур үзүүлэлт

Үндсэн үзүүлэлт:

- Тухайн байгууллагад 3-аас доошгүй жил үндсэн ажилтнаар үр бүтээлтэй ажилласан байх

Тусгай үзүүлэлт/Тухайн ондоо дараах үзүүлэлтийг хангасан байх/

5.3.1 Тухайн жилдээ аваарь, осол, технологийн зөрчилгүй ажилласан байх-20 оноо

5.3.2 Шинэ техник, технологи, аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байх, 1-ээс доошгүй бүтээлч ажил хийж, шинэ санаачилга гаргасан байх-20 оноо

5.3.3 Тухайн ондоо хөдөлмөрийн сахилгын шийтгэл хүлээгээгүй байх-20 оноо

5.3.4 Ажлын цаг ашиглалт, олон нийтийн ажилд оролцсон байдал-20 оноо

5.3.5-Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлсэн байх-20 оноо

5.4. "Тэргүүний ажилтан " шалгаруулах шалгуур үзүүлэлт

Үндсэн үзүүлэлт:

- Тухайн байгууллагад 3-аас доошгүй жил үндсэн ажилтнаар үр бүтээлтэй ажилласан байх

Тусгай үзүүлэлт/Тухайн ондоо дараах үзүүлэлтийг хангасан байх/

5.4.1.Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлсэн байх-30 оноо

5.4.2. Эдийн засгийн үр ашигтай ажилласан байх-20 оноо

5.4.3 .Тухайн ондоо хөдөлмөрийн сахилгын шийтгэл хүлээгээгүй байх-15 оноо

5.4.4 Тухайн байгууллагадаа 1-ээс доошгүй бүтээлч ажил хийж, шинэ санаачилга гаргасан байх-20 оноо

5.4.5 Олон нийтийн ажилд идэвх санаачилгатай, манлайлан оролцдог байх, ажлын цаг ашиглалтын зөрчилгүй байх-15 оноо

Зургаа. Шалгаруулах явц

6.1.Энэ журамд заасны дагуу албa, хэлтэс, хэсэг, нэгжүүдээс нэр дэвшигчдийн материалыг жил бүрийн 12 дугаар сарын 05-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Захиргаа, хүний нөөцийн хэлтэст ирүүлнэ.

6.2.Захирлын зөвлөл нэр дэвшүүлсэн ажилтнуудын ирүүлсэн материалд үндэслэн энэхүү журмын 5-р зүйлд тусгасан шалгуур үзүүлэлтийн дагуу нэр дэвшүүлсэн хүн бүрт 0-100 хүртэлх оноо өгч, "Байгууллагын хүндэт дэвтэрт бичигдэх ажилтан"-1, "Хөдөлмөрийн аварга"-1, "Тэргүүний Инженер техникийн ажилтан"-1, "Тэргүүний ажилтан"-5-ийг тус тус шалгаруулна..

6.3.Шалгаруулалтын дүнг Гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулна.

Долоо. Бүрдүүлэх материал

7.1. Энэ журмын 3.1, 3.2, 3.3, 3.4 дэх хэсэгт заасан шагналын төрлөөр нэр дэвшиж байгаа албан хаагчид нь дараах материалыг бүрдүүлнэ.

Үүнд:

7.1.1. Нэр дэвшигчийн анкет

7.2.2 Шалгуур үзүүлэлтийг хангасан тухай албa, хэлтэс, хэсэг, нэгжийн тодорхойлолт

7.1.3 Албa, хэлтэс, хэсэг, нэгжийн хуралдааны тэмдэглэл

Найм. Бусад зүйл

8.1 Албa, хэлтэс, хэсэг, нэгжээс тухайн ажилтныг зөвхөн 1 шагналд нэр дэвшүүлнэ.

8.2 Нийлбэр дүнгээр 80-аас дээш оноо авсан шагналд нэр дэвшигч нараас сонгон шалгаруулна.

8.3 Захирлын зөвлөлийн гишүүдийн өгсөн онооны дундажаар нийт оноог гаргаж дүгнэнэ.

Ес. Шагнал гардуулах үйл ажиллагаа

9.1. Шагналыг жил бүрийн байгууллагын "Шинэ жилийн арга хэмжээ", эсвэл баярын хурлын үеэр гардуулна.